

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын
даргын 2023 оны 98 дугаар тушаалын
6 дугаар хавсралт

Бодлогын хэрэгжилтийн хэлтэс (нэгжийн нэр)-н Эвент хариуцсан мэргэжилтэн (албан тушаалын нэр)

Т.БАТДОРЖИЙН (албан хаагчийн овог, нэр)-н
2025 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

Нэг. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлт ийн хувь
Зорилт 1. “ БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГТ ТУСГАГДСАН АЖЛЫН ХҮРЭЭНД”							
1	Арга хэмжээ-1 “Улаанбаатар өвлийн наадам” арга хэмжээг зохион байгуулах	Оролцогчийн тоо	11000	13000	Нийслэлийн Засаг даргын 2025 оны А/135 дугаар захирамж, тус газрын даргын 2025 оны А/06 дугаар тушаалын дагуу 2025 оны 2 дугаар сарын 15-16-ны өдрүүдэд Баянзүрх дүүргийн 11-р хороо Хүрхрээгийн аман дахь Скайрезорт цанын баазад “Улаанбаатар өвлийн наадам-2025” арга хэмжээг амжилттай зохион байгуулж нийт 7-н төрлийн тэмцээн явагдаж, ОХУ-ын Буриад, Тува, Халимаг, БНХАУ-ын Өвөр Монголын өөртөө засах орны Шилийн гол, Ордос, Шинжаан Уйгур, БНКУ-ын 60-н тамирчид, Монгол улсын 1184 тамирчид оролцсон. Арга хэмжээний үед 1000 гаруй гадаад дотоодын жуулчид ирж сонирхсоноос 5100 гаруй хүн цана, снөүбоард, чарга, 4400 гаруй хүн хоол ундны үйлчилгээ авсан. Нийт төсөв: 176,031,254	2025.02. 15-16	100%
2	Арга хэмжээ-2 “Бүргэдийн баяр” арга хэмжээг зохион байгуулах	Оролцогчийн тоо	8000	12500	Тусгай сонирхлын аялал жуулчлалыг хөгжүүлэх, жуулчны өвлийн улирлын хугацааг уртасгах зорилгоор нийслэлийн Засаг даргын 2025 оны А/278 дугаар захирамжийн хүрээнд “Бүргэдийн баяр-2025”	2025.03. 08-09	100%

					арга хэмжээг 2025 оны 03 дугаар сарын 08-09-ний өдрүүдэд Хан-Уул дүүргийн 8-р хороо Жаргалантийн аманд байрлах “Чингис хааны хүрээ” аялал жуулчлалын цогцолборт зохион байгуулж нийт 3 төрлийн тэмцээн уралдаан зохион байгуулагдав. Тус арга хэмжээнд Баян-Өлгий аймгийн Соёл урлаг, аялал жуулчлал, залуучуудын газар, Хөгжимт драмын театрын нийт 12 хүний бүрэлдэхүүнтэй уран бүтээлчид, Баян-өлгий аймгийн Алтанцөгц, Сагсай, Ногооннуур, Алтай, Улаанхус, Толбо сумдуудын шилдэг нийт 20 бүргэдчид, Бүгд найрамдах Казакстан улсын 2 бүргэдчин, Бүгд найрамдах Киргиз улсын 2 бүргэдчин, Сэлэнгэ, Төв аймгаас тус бүр 1 бүргэдчин нийт 26 бүргэдчид оролцов. Арга хэмжээнд: Хилийн цэргийн дуу бүжгийн чуулгын “Хилчин хамтлаг”, бүжгийн чуулгын “Бүжигчид”, Эртний цуурай ардын хөгжмийн хамтлаг, Улаанбаатар театрын Уртын дуучин Баянжаргал, Этник уран бүтээлч Шижирмаа, Казакстан улсын дуучин Нурбол, МУСТА Д.Бердибек, Баян-Өлгий аймгийн Хөгжимт драмын театрын 12 уран бүтээлч, Үндэсний урлагийн театрын 20 гаруй уран бүтээлчид уран бүтээлчид оролцсон. Нийт төсөв: 58,932,360		
	Арга хэмжээ-3 Олон улсын дугуйн фестиваль	Оролцогчийн тоо	-	-	Уг арга хэмжээг Нийслэлийн биен тамир спортын газраас зохион байгуулахаар болсон тул арга хэмжээ цуцлагдсан.	-	-
	Арга хэмжээ-4 Нийслэлийн иргэдийн баяр Хүрээ-Даншиг наадам 2025	Оролцогчийн тоо	20000	25000	Монгол улсын засгийн газрын 2025 оны 04-р сарын 16-ний өдрийн 194-р тогтоолоор нийслэл Улаанбаатар хотын иргэдийн өдрийг жил бүрийн 6 дугаар сарын дөрөв дэх долоо хоногийн Бямба, Ням гарагт болгон баталсантай холбогдуулан “Иргэдийн баяр, Хүрээ цам-Даншиг наадам” шашин соёлын арга хэмжээг 2025 оны 6 дугаар сарын 27-29 ний өдрүүдэд хүй 7-н худаг Монгол наадам цогцолборт зохион байгуулахаар төлөвлөн байгууллагуудаас төсвийн санал авч захирамжийн төсөл боловсруулан бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна.	2025.05.	50%

Зорилт 2. “ХУУЛИАР ОЛГОСОН ЧИГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЧИГЛЭЛЭЭР”							
4	Хариуцсан ажлын хүрээнд холбогдох бүх төрлийн судалгааг гаргаж, мэдээллийн сан үүсгэх	Гүйцэтгэлийн хувь	100	100	Улаанбаатарын өвлийн наадам” иргэдийн сэтгэл ханамжийн судалгаа болон эдийн засгийн үр өгөөжийн судалгаа, сошиал хандалтын судалгааг СЭЗИС-н мэргэжлийн багш оюутнуудтай хамтран Эвентийн төлөвлөлт, урлаг соёлын арга хэмжээ, Хоол ундны үйлчилгээ, Аюулгүй байдал гэсэн судалгааг авч ажилласан.	I-улирал	100%
Зорилт 3. “ТӨРИЙН ЖИНХЭНЭ АЛБАН ХААГЧИЙН НИЙТЛЭГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЖ АЖИЛЛАХ” ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД							
6	2025 онд зохион байгуулах эвент, арга хэмжээний хуваарь, видео шторк гарган олон нийтэд хүргэх	Гүйцэтгэлийн хувь	100	100	Байгууллагын 2025 оны үйл ажиллагааны төвлөвлөгөөнд тусгагдсан эвент арга хэмжээний хуваарийг боловсруулан батлуулав. “Улаанбаатар өвлийн наадам-2025” арга хэмжээний сурталчилгааны 6 шторк, видео контент гарган олон нийтэд хүргэсэн.	I-II улирал	100%
	Эвент, арга хэмжээнд жижиг дунд үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгч иргэд, аж ахуй нэгжүүдийн бараа бүтээгдэхүүнийг сурталчлан орлогыг нэмэгдүүлэх	Оролцогчийн тоо	-	100-150	Жижиг дунд үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгч иргэд, аж ахуй нэгжүүдийн бараа бүтээгдэхүүнийг сурталчлан орлогыг нэмэгдүүлэх ажлын хүрээнд “Улаанбаатарын өвлийн наадам-2025” арга хэмжээнд 4 ААН, 2 НҮТББ, “Нарны баяр 2025” арга хэмжээнд 2 НҮТББ, ЖДҮ 56 ААН -үүдийг хамруулан нийт,,,, төгрөгийн орлого олсон байна.	I-IV улирал	70%

Нэмэлт үүрэг даалгавар (арга хэмжээ)-ын биелэлт

Д/д	Үүрэг даалгавар (арга хэмжээ)	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлт ийн хувь
1	“Нарны баяр 2025”	Оролцогчийн тоо	4500	5000	Нийслэлийн засаг даргын 2025 оны А/332 дугаар захирамж, тус газрын 2025 оны А/11 дүгээр тушаалын дагуу 2025 оны 03 дугаар сарын 22 ний өдөр жанжин Д.Сүхбаатарын талбайд “Нарны баяр 2025” арга хэмжээг амжилттай зохион байгууллаа. Энэхүү арга хэмжээ нь зөвхөн Монголд төдийгүй дэлхийн хэмжээнд Монголын		100%

					Наурызын баярыг танилцуулахад чухал үүрэг гүйцэтгэсэн. "Нарны баяр 2025" арга хэмжээг 122,000 орчим хүн үзэж сонирхсон бөгөөд, 4500-5000 орчим хүн оролцсон байна.Эдийн засгийн үр өгөөжийн хувьд Жижиг дунд үйлдвэрлэгчдийн 56-н аж ахуйн нэгж оролцсон бөгөөд Нийт: 67,356,000 төгрөгийн орлого олсон байна.	2025.03. 22	
2	"УБ фүүд фестивал" олон улсын хоолны өдөрлөг 2025	-	-	-	"Монголд зочлох жил"-ийн хүрээнд Улаанбаатар хотын аялал жуулчлалыг хөгжүүлэх, жуулчны улирлын хамаарлыг бууруулах, шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээг бий болгох, хотын соёлыг түгээн дэлгэрүүлэх, иргэдийн амралт, чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх зорилгоор 2025 оны 04 дүгээр сарын 07-13ны өдрүүдэд Жанжин Д.Сүхбаатарын талбайд зохион байгуулсан "Олон улсын хоолны өдөрлөг" арга хэмжээний төв тайз угсралт болон урлаг соёлын арга хэмжээг зохион байгуулсан. Уг арга хэмжээнд үндсэн уран бүтээлчээр: хөтлөгч Мачо, XVII хамтлаг, Дуучин Цогсогмаа, DJ Билгүүн, Саксафон хөгжимчин Ган-эрдэнэ, Б.Одмандах, Улаанбаатар театр, Open mic, Freezone хамтлаг, Зочин уран бүтээлч: Лемонс хамтлаг, The baatar ,A sound хамтлаг, Ub drums, Sun juniper хамтлаг дуучин Тэгшээ, Tree life sisters, ёочин хөгжимчин Марал-од оролцсон 6 хоногийн турш тайзны арга хэмжээнд оролцсон.	2025.04. 07-12	100%
3	Агаар бохирдуулагч эх үүсвэрийн судалгааг гаргах.	-	-	-	Нийслэлийн Засаг даргын А/33-р захирамжийн дагуу СХД-ийн 28 дугаар хороонд агаар бохирдуулагч эх үүсвэрийн хяналт шалгалтын ажлыг 2025 оны 01-р сарын 18-19-ний өдрүүдэд хийсэн.	2025.01. 18-19	100%
4	Эзэнгүй золбин нохой, муурын тоог цөөрүүлэх устгах ажил	-	-	-	Захирагчийн ажлын албанаас зохион байгуулсан Эзэнгүй золбин нохой, муурын тоог цөөрүүлэх устгах ажилд 2025 оны 5 дугаар сарын 24-25өдөр ЧД-н 19-24 р хороонд ажилласан.	2025.04. 24-25	100%

5	Улаанбаатар хотын соёлын өдөрлөг Будапешт хот	-	-	-	Нийслэлийн Засаг даргын 2025 оны А/470 дугаар захирамжын дагуу Унгар улсын Будапешт хотод “Улаанбаатарын соёлын өдрүүд” арга хэмжээг 2025 оны 05 дугаар сарын 10-ний өдрөөс 11-ний өдрүүдэд зохион байгуулав. Нийслэлийн Аялал жуулчлалын газрын зүгээс АЖМХ-НЭЗХЭ-ийн Европ зах зээлийн салбар холбооны гишүүн 8 байгууллага болон Монгол Гастроном холбоо, Морьт харваан холбооны төлөөллүүдийг оролцуулж Улаанбаатар хотын аялал жуулчлалыг сурталчлан зохион байгуулалтад ажиллав.	2025.05. 05-11	100%
6	Бурхан багшийн их дүйчэн өдөр 2025	-	-	-	МБШТ Гандантэгчинлэн хийдтэй хамтран Бурхан багшийн их дүйчэн өдрийг 2025 оын 6-р сарын 11-ний өдөр зохион байгуулахаар төлөвлөн төсвийн санал боловсруулан бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна.	2025.05. 29	50%

Хоёр. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлт ийн хувь
	1	2	3	4	5	6	7
1	Төрийн худалдан авах ажиллагааны сургалтад хамрагдах	-	-	-	Төрийн худалдан авах ажиллагааны газраас 2025 оны 02-р сарын 03,04,05-ний өдрүүдэд Төрийн худалдан авах ажиллагааны мэргэшсэн ажилтан бэлтгэх сургалтад хамрагдав.	2024.04. 05,08-09	100%
2	Монгол бичгийн цахим бичгийн сургалтад хамрагдах	-	-	-	НЗДТГ-н хүний нөөцийн хөгжлийн хэлтэсээс зохион байгуулсан Монгол бичгийн цахим бичвэрийн сургалтад 2025оны 05.22 өдөр хамрагдав	2025.05. 22	100%

ТАЙЛАН ГАРГАСАН:

Эвент хариуцсан мэргэжилтэн
(Албан тушаал)

Т.Батдорж /  /
(Нэр, гарын үсэг)

2025.06...
(Огноо)

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын
даргын 2023 оны 98 дугаар тушаалын
5 дугаар хавсралт

НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН ЭВЕНТ ХАРИУЦСАН
МЭРГЭЖИЛТЭН Т.БАТДОРЖИЙН 2024 ОНЫ НЭМЭЛТ ҮҮРЭГ ДААЛГАВРЫН ХУУДАС
Нэмэлт үүрэг даалгавар (арга хэмжээ)


Д/д	Үүрэг даалгавар	Үүрэг даалгавар өгсөн удирдах албан тушаалтан	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Хүрэх түвшин	Эхлэх хугацаа	Дуусах хугацаа
1.	Үүрэг даалгавар (арга хэмжээ) 1. “Нарны баяр 2025”	Газрын дарга	Хэрэгжилтийн хувь	100 хувь	100 хувь	03.21	03.21
2.	Үүрэг даалгавар (арга хэмжээ) 2. “УБ фүүд фестивал” олон улсын хоолны өдөрлөг 2025	Газрын дарга	Хэрэгжилтийн хувь	100 хувь	100 хувь	04.07	04.12
3.	Үүрэг даалгавар (арга хэмжээ) 3. Агаар бохирдуулагч эх үүсвэрийн судалгааг гаргах.	Газрын дарга	Хэрэгжилтийн хувь	100 хувь	100 хувь	01.18	01.19
4.	Үүрэг даалгавар (арга хэмжээ) 4. Эзэнгүй золбин нохой, муурын тоог цөөрүүлэх устгах ажил.	Газрын дарга	Хэрэгжилтийн хувь	100 хувь	100 хувь	05.24	05.25
5.	Үүрэг даалгавар (арга хэмжээ) 5. “Улаанбаатар хотын соёлын өдөрлөг” Будапешт хот	Газрын дарга	Хэрэгжилтийн хувь	100 хувь	100 хувь	05.6	05.12
6.	Үүрэг даалгавар (арга хэмжээ) 5. Бурхан багшийн их дүйчэн өдөр 2025	Газрын дарга	Хэрэгжилтийн хувь	100 хувь	100 хувь	06.11	06.11

НЭМЭЛТ ҮҮРЭГ ДААЛГАВАР АВСАН:

Эвент хариуцсан мэргэжилтэн

ХЯНАН БАТАЛГААЖУУЛСАН:

Бодлогын хэрэгжилтийн хэлтсийн дарга

 / Т.Батдорж /
 / С.Туул /

2025.06.10

2025.06.10